



## УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АУДИТЫН СЭДЭВ: ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН 2021-2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

**АУДИТЫН КОД: УВА-2024/39-ШТА-ГА**

**АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:** Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын төлөвлөгөө батлах тухай” 8 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/152 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө;

**АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ:** Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу бүрдүүлсэн ч зарцуулалтын үр дүн хангалтгүй, хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХҮРГҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГА:**

- Үндэсний аудитын газар,
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал,
- Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар,
- Сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлэв.

Улаангом сум 2024 оны 10 дугаар сар

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

### Аудитын зорилт

Хоршоо хөгжүүлэх сангийн 2021-2023 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ Үүнд:

- Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу бүрдүүлж, шаардлага хангасан төслийг сонгон шалгаруулсан эсэх;
- Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх;
- Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн зарцуулалтад хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, мэдээ тайланг журамд заасан хугацаанд гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн эсэх;

### Аудитын хамарсан хүрээ

Аудитад Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын хүрээнд 2021-2023 онуудад олгосон зээл болон эргэн төлөлтийн баримт, аймаг, сумдын Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газар, хороо болон хяналтын зөвлөл, Хоршоо хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтний зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ажлын тайлан, холбогдох бусад баримт материалыг хамрууллаа.

### Арга зүй

Аудитад гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглав.

### Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын стандартыг хангуулан, үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Авирмэд, аудитор Р.Аюуш, гэрээт аудитор С.Алтанхундага нар хийж гүйцэтгэлээ.

Аудитад оролцсон хүний нөөцийн хүрэлцээ, цаг хугацаанаас хамаарч Улаангом болон бусад 5 суманд очиж ажилласан болно.

### Үндсэн мэдээлэл

Увс аймагт 2021 онд 129 зээлдэгчид 930.4 сая, 2022 онд 98 зээлдэгчид 1,827.1 сая, 2023 онд 64 зээлдэгчид 1,038.5 сая төгрөгийн зээлийг Хоршоо хөгжүүлэх болон Сум хөгжүүлэх сангаас олгосон байна.

Аудитад хамрагдсан 2021 онд олгосон зээлийн хэрэгжилтэд Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”, 2022, 2023 онд олгосон зээлийн хэрэгжилтэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг баримтлав.

## **БҮЛЭГ: А. ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ БҮРДҮҮЛСЭН Ч, БИЧИГ БАРИМТЫН БҮРДЭЛ ДУТУУ ТӨСЛИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛСАН БАЙНА.**

### ***А.1. Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу бүрдүүлсэн байна.***

Улсын төсвөөс 2011-2014 онд сумдын Хоршоо хөгжүүлэх санд 4,229.0 сая төгрөгийг олгосноор Хоршоо хөгжүүлэх сангийн анхны эх үүсвэр бүрдсэн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэр 5,368.9 сая төгрөг болж анх хуваарилснаас 1,139.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Сангаас аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөр, зээлийн хүү, хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүнд ногдуулсан алдангийн орлогоор сангийн эх үүсвэр нэмэгдсэн байна.

Харин гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив болон бусад эх үүсвэрээс санд хөрөнгө төвлөрөөгүй байна.

### ***А.2. Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хороо, хяналтын зөвлөлийг хууль журамд заасны дагуу байгуулсан байна.***

Сумдын ИТХ 2016-2021 онд төсөл сонгон шалгаруулах болон хяналтын зөвлөлийг байгуулсан байна. Мөн төсөл сонгон шалгаруулах хороо болон хяналтын зөвлөлийг 2022, 2023 онд сумдын ИТХ-ын шийдвэрээр шинэчлэн байгуулсан байна.

Журамд заасны дагуу хороо болон хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 19 сумын ИТХ-аас томилсон байна.

### ***А.3. Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хороо нь журамд заасан шаардлага бүрэн хангаагүй төслийг сонгон шалгаруулсан байна.***

2021-2023 онд сангийн хөрөнгөөр төсөл хэрэгжүүлэх, зээлдэгчдийн бүрдүүлэх материал, төсөлд тавигдах шаардлагыг дээрх заалт тус бүрээр үнэлэн үзэхэд холбогдох баримт материалын бүрдэл дутуу төсөлд зээл олгосон байна.

Тухайлбал суманд оршин сууж үйл ажиллагаа явуулдаг тухай тодорхойлолт, зээлийн болон барьцааны гэрээ байгуулахдаа барьцаалах үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг тогтоох чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан дүгнэлт гаргуулах бөгөөд үл хөдлөх хөрөнгийг тухайн үеийн зах зээлийн үнэлгээний 70 хүртэл хувиар

үнэлэх, барьцаанд үл хөдлөх хөрөнгө гэснийг зөрчин, мал, машин тоног төхөөрөмж барьцаалсан төсөлд зээл олгосон, журмын 5.5.8-5.5.15 дахь хэсгүүдэд заасан төсөлд хавсаргах баримт материалыг хавсаргаагүй, барьцаанд тавьсан эд хөрөнгийн итгэмжлэлийн хугацаа олгосон зээлийн төлөх хугацаанаас зөрүүтэй байх зэрэг зөрчлүүд нийтлэг илэрч байна.

Цаашид журамд заасан шалгуурыг баримталж, шаардлага бүрэн хангасан төсөлд зээл олгож байхыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж болголоо.

Мөн Баруунтуруун, Тариалан, Ховд, Өмнөговь, Тэс сумд төсөл сонгон шалгаруулахдаа хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдүүлэг гаргаагүй байна. Цаашид төсөл сонгон шалгаруулахдаа хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдүүлэг хөтөлж байхыг зөвлөлөө.

## **БҮЛЭГ: Б. ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ, ЗОРИУЛАЛТЫН БУС ЗАРДАЛ ГАРГАСАН БАЙНА.**

***Б.1. Хоршоо хөгжүүлэх сангаас авсан зээлийг 6 зээлдэгч зориулалтын дагуу зарцуулаагүй, сумууд сангаас зориулалт бус зардал гаргасан байна.***

Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөс 2021 онд 129 зээлдэгчид 930.4 сая, 2022 онд 98 зээлдэгчид 1,827.1 сая, 2023 онд 64 зээлдэгчид 1,038.5 сая, нийт 291 зээлдэгчид 3,796.0 сая төгрөгийн зээлийг олгосон байна.

Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 11.1-д заасны дагуу Өлгий сумын Засаг даргын 2022 оны А/18 захирамжаар 1 зээлийн гэрээг, Тариалан сумын Засаг даргын 2022 оны А/43, А/44 дүгээр захирамжуудаар 2 зээлийн гэрээг, 2023 оны А/20 дугаар захирамжаар 1 зээлийн гэрээг цуцалсан байна.

Аудитын явцад түүврээр 6 сумын зээлдэгчдийн хэрэгжүүлж байгаа төсөлтэй газар дээр нь танилцаж хяналт хийхэд Улаангом сумын 4, Өлгий сумын 1, Өмнөговь сумын 1, нийт 6 зээлдэгчтэй холбоотой дараах зөрчил илэрсэн.

Аудитад хамрагдсан онуудад төсөл сонгон шалгаруулах зөвлөл, хороогоор хэлэлцүүлэхгүйгээр 2021 онд 3, 2022 онд 1 төсөлд, хороогоор орсон ч дэмжигдээгүй 1 төсөлд 2022 онд Улаангом сумын Засаг даргын захирамжаар зээл олгосон байна. Эдгээр 5 зээлдэгчээс 2021 онд зээл авсан 3 зээлдэгч зээлээ 2023 онд төлж барагдуулсан байна. Харин 2022 онд зээл авсан 2 зээлдэгч зээлийн үлдэгдэлтэй байна.

Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгах бөгөөд хөнгөлөлттэй зээлийг зориулалтын бусаар зарцуулсан, зээлийн гэрээнд заасан заалтыг зөрчсөн 8 зээлдэгчийн зээлийн гэрээг цуцалж үлдэгдлийг сангийн дансанд төвлөрүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөмж болголоо.

Мөн журмын 4.8-д “Хорооны төсөл сонгон шалгаруулсан шийдвэр нь тухайн төсвийн жилдээ хүчин төгөлдөр байна” гэж заасныг зөрчин 2022 онд гарсан хорооны шийдвэрийг үндэслэн Улаангом сумын иргэн Х.Батзоригийн “Конкрет блок, блокон хашаа бүтээц” төсөлд 13.0 сая төгрөгийн зээлийг Улаангом сумын Засаг даргын захирамжаар 2023 онд олгосон байна. Улаангом сумын Засаг даргын захирамжаар Б.Эрдэнэзаяагийн “Эмийн сангийн үйлчилгээ” төсөлд 2022 онд 30.0

сая төгрөгийн зээл олгосон нь Улаангом сумын ИТХ-ын 2022 оны 8/03 дугаар тогтоолоор баталсан зээл олгох тэргүүлэх чиглэлтэй нийцэхгүй байна.

Цаашид журмын заалтыг баримталж зээл олгож байхыг холбогдох албан тушаалтанд зөвлөмж болголоо.

Түүнчлэн “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.2-т, 1.4-т заасныг зөрчиж аймгийн Засаг даргын 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 1/873 дугаар албан бичгээр “...Сумдын мал хамгаалах сангаас аймагт төлөх өглөгийг мал хамгаалах сангийн 100150051404 тоот дансанд төлж барагдуулан дансанд бүртгэлтэй хөрөнгө, авлагыг Сум хөгжүүлэх санд шилжүүлэн бүртгэх” чиглэлийг сумдын Засаг дарга нарт өгсөн байна. Тус чиглэлийг үндэслэн Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс аймгийн Мал хамгаалах санд бүртгэлтэй байсан өглөгийг төлж, Мал хамгаалах сангийн авлагыг Сум хөгжүүлэх санд шилжүүлэн 9 сумын 64.0 сая төгрөгийн Мал хамгаалах сангийн авлагыг Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс төлж авлагыг шилжүүлэн бүртгэсэн байна.

Мөн Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 2.7-д заасныг зөрчсөн дараах сумууд байна.

- Малчин сум 2022 онд хүүгийн орлогыг журамд заасан хэмжээнээс 0.8 сая, 2023 онд 0.3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.
- Сагил сум 2023 онд хүүгийн орлогыг журамд заасан хэмжээнээс 0.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

Цаашид Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийг журамд заасны дагуу зарцуулахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж болголоо.

### ***Б.2. Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан хоршоо, иргэд ажлын байрыг нэмэгдүүлсэн ч нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажаагүй байна.***

Журмын 7.11-д тодорхой тусгасан ч нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажсан ажлын байрны тоо хангалтгүй байна. Төсөлд тусгасан болон нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажсан ажлын байрны тоо 2021 онд төслөөр 282 ажлын байр бий болгохоор төлөвлөсөн ч НДШ төлөлтөөр 4 ажлын байр, 2022 онд төслөөр 246 ажлын байр бий болгохоор төлөвлөсөн ч НДШ төлөлтөөр 23 ажлын байр, 2023 онд төслөөр 160 ажлын байр бий болгохоор төлөвлөсөн ч НДШ төлөлтөөр 24 ажлын байр, нийт төслөөр 688 ажлын байр бий болгохоор төлөвлөсөн ч НДШ төлөлтөөр 51 ажлын байр бий болсон нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлдэгчдийн НДШ төлөлт хангалтгүй байгааг харуулж байна.

Иймд төсөл хэрэгжүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, хоршооны төсөлд бодитоор бий болгох ажлын байрны тоог тусгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх талаар зөвлөмж чиглэл хүргүүлж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөлөө.

### ***Б.3. Хоршоо хөгжүүлэх сангаас авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд төвлөрүүлээгүйгээс зээлийн үр дүн буурч байна.***

Аудитад хамрагдаж буй онуудад олгосон зээлээс чанаргүй зээл байхгүй бөгөөд 2021 оны 2,353.3 сая төгрөгийн чанаргүй зээл нь 2011 оноос эхлэн он дамжин хуримтлагдсан үлдэгдэл байна.

Судалгаанаас харахад 2023 оны байдлаар 635 зээлдэгч 4,144.1 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаагаас хэвийн төлөлттэй зээл 55.4 хувь буюу 2,296.4 сая, хугацаа хэтэрсэн зээл 12.9 хувь буюу 534.0 сая, чанаргүй зээл 31.7 хувь буюу 1,313.7 сая төгрөг байгаа нь зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгааг харуулж байна. Үүнээс шалтгаалж зээлийн эргэлт удааширч, Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд нөлөөлж байна.

Сумдын Засаг дарга нар хугацаа хэтэрсэн зээлийг эргэн төлүүлэхийн тулд зээлдэгчид мэдэгдэл хүргүүлэх, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, Монгол банкны зээлийн мэдээллийн санд мэдээллийг нийлүүлэх зэрэг арга хэмжээг авч ажилласнаар Хоршоо хөгжүүлэх сангийн хэвийн зээлийн хэмжээ жил бүр өсөн нэмэгдэж, чанаргүй зээлийн хэмжээ буурч байна. Тухайлбал: Хэвийн зээлийн хэмжээ 2021 онд 1,410.9 сая төгрөг байсан бол 2023 онд 2,296.4 сая төгрөг болж 885.5 сая төгрөгөөр буюу 62.7 хувиар нэмэгдсэн, чанаргүй зээлийн хэмжээ 1,039.6 сая төгрөгөөр буюу 44.1 хувиар буурснаар эерэг үр нөлөө гарч байна.

Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 3.4.11-т заасны дагуу дагуу хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулж ажиллах, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, Монгол банкны зээлийн мэдээллийн санд мэдээллийг нийлүүлэх зэрэг арга замаар чанаргүй зээлийн үлдэгдлийг барагдуулахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж болголоо.

Улаангом, Өмнөговь, Сагил, Баруунтуруун, Бөхмөрөн, Зүүнхангай сумын холбогдох мэргэжилтнүүд 2020-2021 онд зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчдийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд бүрэн оруулаагүй байна.

Мөн журмын 7.3-д заасныг хэрэгжүүлэн дээрх зээлдэгч нарын мэдээллийг зээлийн мэдээллийн санд үнэн зөвөөр оруулж үүссэн зөрчлийг арилгахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж болголоо.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн мэдээллийн сангийн программын авлагын дүн нь санхүүгийн тайлангийн авлагын дүнгээс Бөхмөрөн 8.9 сая, Зүүнговь 2.6 сая, Зүүнхангай 2.0 сая, Малчин 11.0 сая, Өмнөговь 30.8 сая, Сагил 8.9 сая, Түргэн 0.3 сая, Тэс 30.5 сая, Улаангом 40.5 сая төгрөгийн зөрүүтэй байна.

Цаашид зээлийн мэдээллийн сангийн авлагыг үнэн зөв тайлагнахыг холбогдох албан тушаалтанд зөвлөмж болголоо.

## **БҮЛЭГ:В. ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗЭЭЛИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ, МЭДЭЭ ТАЙЛАНГ ЖУРАМД ЗААСАН ХУГАЦААНД ГАРГАЖ ХОЛБОГДОХ ГАЗРУУДАД ХҮРГҮҮЛСЭН БАЙНА.**

***В.1. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд 9 сумын хяналтын зөвлөл хяналт хангалтгүй хэрэгжүүлсэн байна.***

Журмын 7.4-д заасны дагуу сумдын хяналтын зөвлөл нь сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг харилцан адилгүй хийдэг, зарим жилд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аудитад хамрагдсан онуудад Зүүнхангай сум хяналт хэрэгжүүлээгүй, Давст, Малчин, Өмнөговь, Түргэн, Тэс, Цагаанхайрхан, Ховд, Хяргас сумд жил бүр хяналт хийгээгүй байна.

Иймд дээрх сумдын хяналтын зөвлөлд хяналт шалгалтыг журамд заасны дагуу хийж байхыг зөвлөмж болголоо.

Харин аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн “Увс аймгийн сумдад санхүүгийн хяналт шалгалт хийх удирдамж”-ийн дагуу Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Хүнс, хөдөө аж ахуйн газар, аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсэг сумдад хяналт шалгалт хийн ажилласан байна.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2023 онд баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг Улаангом сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2022 оны үйл ажиллагааны баримт, зээлийн хэрэгжилтэд хяналт хийж ажилласан байна.

Аудитад хамрагдсан онуудад хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтын дүн дүгнэлтээс харахад сумдын гаргаж байгаа зөрчил нь арилахгүй, давтан гарч байгаа нь хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн биелэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ хангалтгүй байгааг харуулж байна.

Иймд сумдаар хийсэн хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг тооцож, хяналт шалгалтын үр дүнг дээшлүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын холбогдох албан тушаалтанд зөвлөлөө.

***В.2. Сангийн орлого, зарлагын тайланг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлсэн ч зарим сумд үйл ажиллагааны тайлангаа Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлээгүй байна.***

Аудитад хамрагдсан 2021-2023 онд сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар төсөл сонгон шалгаруулах хороо, хяналтын зөвлөлийг байгуулж, төслийн сонгон шалгаруулах тов тогтоох, зээл олгох тэргүүлэх чиглэл батлуулж, сангаас тухайн жилд олгох зээлийн дээд хэмжээг тогтоож ажилласан байна.

2021 онд сумд Сум хөгжүүлэх сангийн орлого, зарлагыг тухайн шатны ИТХ-аар батлуулсан байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн төсвийг 2022, 2023 онуудад сумын төсөвтэй нэгтгэн батлуулсан байна.

Сумдын Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар жил жилийн сангийн төсвөө батлуулдаг ч үйл ажиллагааны тайлангаа зарим сумд тайлагнаагүй байна. Үүнд:

2022 оны байдлаар:

- Баруунтуруун, Зүүнговь, Зүүнхангай, Малчин, Сагил, Тариалан, Түргэн, Ховд, Хяргас сумд

2023 оны байдлаар:

- Давст, Зүүнговь, Зүүнхангай, Тариалан, Түргэн, Цагаанхайрхан, Ховд сумд үйл ажиллагааны тайланг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллаагүй байна.

Иймд дээрх сумдын Засаг дарга нарт Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны тайланг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж байхыг зөвлөмж болголоо.

Журмын 7.5-д заасны дагуу сумдын холбогдох мэргэжилтнүүд Хоршоо хөгжүүлэх сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг улирал болон жилээр гаргаж цахим болон цаасаар ХХААГ-т хүргүүлсэн байна.

Харин журмын 7.6-д заасны дагуу Аймгийн Засаг дарга нь ХХААГ-аар дамжуулан журмын дагуу аймгийн Хоршоо хөгжүүлэх сангийн орлого, зарлагын

гүйцэтгэлийн улирлын болон жилийн тайланг нэгтгэн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн ажилласан байна.

***В.3. Мэдээллийн ил тод байдлыг 8 сумаас бусад нь хангаж ажилласан, сумд зээлдэгчийн мэдээллийн санг бүрдүүлсэн байна.***

Сумд 2021-2023 онуудад төсөл сонгон шалгаруулах тов, тавигдах шаардлага, төслийн чиглэлийг олон нийтийн цахим сүлжээ болон Засаг даргын Тамгын газрын нийтийн мэдээллийн самбарт байршуулсан байна.

Журмын 8.3-д заасны дагуу 2022, 2023 онд ил тод нийтэд мэдээлсэн байдлыг ихэнх сумд ханган ажиллаж байгаа боловч зарим сумууд журмын заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Үүнд:

2022 онд: Баруунтуруун, Бөхмөрөн, Зүүнхангай, Өлгий, Өмнөговь, Түргэн, Тэс, Ховд сумд

2023 онд: Баруунтуруун, Бөхмөрөн, Зүүнхангай, Түргэн, Тэс, Ховд сумууд нь мөрдөгдөж буй

Иймд дээрх сумдын удирдлага, мэргэжилтнүүдэд журамд заасны дагуу зээлдэгчийн мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлж ажиллахыг зөвлөмж болголоо.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг 2020 оноос эхлэн Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэж эхэлсэн байна.

Журмын 9.3-т заасны дагуу Жижиг дунд үйлдвэрийн газрын дарга, аймгийн ХХААГ-ын даргатай 2022 оноос мэдээлэл нийлүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

## ДҮГНЭЛТ

*Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:*

1. Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу бүрдүүлсэн байна.
2. Журамд заасан шалгуур, шаардлагыг бүрэн хангаагүй 174 төсөлд зээл олгосон, төсөл сонгон шалгаруулах хороогоор дэмжигдээгүй 2 зээлдэгчид 38.0 сая төгрөгийн зээл өгснөөс зайлшгүй шаардлагатай төслүүдэд зээл олгох боломжийг хязгаарласан байна.
3. Хоршоо хөгжүүлэх сангаас 121.3 сая төгрөгийг зориулалт бус зүйлд зарцуулсан, 6 зээлдэгч 117.0 сая төгрөгийн зээлээ зориулалтын дагуу зарцуулаагүй нь сангийн ач холбогдлыг бууруулах, эх үүсвэр дутагдах нөхцөлийг үүсгэж байна.
4. 2023 оны жилийн эцсийн өссөн дүнгээр нийт зээлийн 12.9 хувь буюу 533.9 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 31.7 хувь буюу 1,313.7 сая төгрөгийн чанаргүй зээл эзэлж байгаа нь зээлийн эргэн төлөлт буурах, сангийн эх үүсвэр дутагдах эрсдэлтэй байна.



5. Сангийн үйл ажиллагааны тайланг зарим сумд Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлээгүй, 9 сум сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
6. Зээлийн мэдээллийн санд зарим зээлдэгч нарын мэдээллийг бүрэн оруулаагүй, зээлийн мэдээллийн сангийн авлагын дүн санхүүгийн тайлангийн авлагын дүнгээс зөрүүтэй, 8 сум мэдээллээ байршуулаагүй зэргээс шалтгаалж мэдээллийн ил тод байдал алдагдах, иргэд үнэн зөв мэдээллээр хангагдах боломжийг алдагдуулсан байна.

### **ЗӨВЛӨМЖ**

**Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна. Үүнд:**

**Сумдын Засаг дарга нарт:**

1. Журамд заасан шалгуур, шаардлагыг бүрэн хангасан төсөлд зээл олгож байх.
2. Сангийн хөрөнгийг журамд заасан зориулалтын дагуу зарцуулах, авсан зээлээ зориулалт бусаар зарцуулсан 6 зээлдэгч болон төсөл сонгон шалгаруулах хороогоор дэмжигдээгүй 2 төсөлд олгосон зээлийн гэрээг цуцалж зээлийн төлөгдөөгүй үлдэгдлийг сангийн дансанд төвлөрүүлэх.
3. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлүүдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, Монгол банкны зээлийн мэдээллийн санд мэдээллийг нийлүүлэх зэрэг арга замаар барагдуулах.
4. Сангийн үйл ажиллагааны тайланг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлэх, хяналт шалгалтыг журамд заасны дагуу хийж байх.
5. Зээлийн мэдээллийн санг бүрэн хөтлөх, сангийн авлагыг үнэн зөв илэрхийлэх, цахим хуудсаараа дамжуулан мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах.